

# “МОНОС ХҮНС” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 15-ны өдөр

№ МХ06/201905

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус  
хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн Тухай Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10, 60-р зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, 61-р зүйлийн 61.1.5, 76-р зүйлийн 76.1.2 заалт болон Компанийн дүрмийн 7-р зүйлийн 7.2, 7.4, 7.5.1, 7.5.2, 7.5.6, 7.5.12, 7.7 заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 06 сарын 26-ний Лхагва гарагийн 14.00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Гэсэр сүмийн баруун талд байрлах “Holiday-inn” зочид буудлын хурлын танхимд хуралдуулеугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
  1. “Монос хүнс” ХХК-ийг ХК болгон хэлбэрийг өөрчлөх.
  2. “Монос хүнс” ХК-ийн дүрмийн санг өөрчлөх, шинэчилсэн дүрмийг батлах
  3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
  4. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 06 сарын 05-ны өдрөөр тасалбар болгосугай.
4. Хурлын зарыг тогтоолын Хавсралт №01-аар батлан, Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон телевизээр дамжуулан 2019 оны 05 сарын 20-ны өдөр нийтэд мэдээлж, зарын давгалтыг 2019 оны 06 сарын 04-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцахыг хүсвэл ажлын өдрүүдэд 10:00-16:00 цагийн хооронд Хан-Уул дүүргийн 2 хороо, Монос хүнс үйлдвэрийн байранд ирж танилцах боломжтой болохыг мэдээлсүгэй.
6. Хурлын Саналын хуудсыг энэ тогтоолын Хавсралт №02-оор батлаж, хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээ саналын хуудсаар санал авах сүүлчийн хугацааг 2019 оны 06 сарын 21-ний өдрөөр тасалбар болгож саналын хуудсыг брокер дилерийн компаниуд болон компанийн байранд хүлээн авахаар тогтоосугай.
7. Хурлын даргаар “Монос хүнс” ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал П.Тодролыг, хурлын үеэр ажиллах тооллогын комиссын даргаар санхүүгийн менежер Э.Амарболд, гишүүдээр хуульч Н.Цагаанхүү, тооцооны нягтлан бодогч Г.Буяндэлгэр нарыг томилж, хурал зохион байгуулах ажлыг Компанийн тухай хууль, эрх бүхий байгууллагаас гаргасан журам, бусад баримт бичигт нийцүүлэн зохион байгуулахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.ХҮРЭЛБААТАР